



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/270

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, "2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн Тэжээлийн нөөц бүрдүүлэх худалдан авах ажлыг "Энэ сайхан" хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай

3. Зардалд шаардагдах 22,000,000 (хорин хоёр сая) төгрөгийг гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгө данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч баримтжуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Н.ОРХОНТУУЛ

